

ЦӨМИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ 1994 ОНЫ КОНВЕНЦ,  
АШИГЛАСАН ТУЛШНИЙ БОЛОН ЦАЦРАГ ИДЭВХТ ХАЯГДЛЫН  
МЕНЕЖМЕНТИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ 1997 ОНЫ  
КОНВЕНЦ, ЦӨМИЙН МАТЕРИАЛЫГ БИЕЧЛЭН ХАМГААЛАХ ТУХАЙ  
1980 ОНЫ КОНВЕНЦЫН 2005 ОНЫ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ, БАГА  
ХЭМЖЭЭНИЙ ЦӨМИЙН МАТЕРИАЛЫН ШИНЭЧИЛСЭН  
ПРОТОКОЛЫГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ АЮУЛГҮЙ  
БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2023 оны 11 дүгээр  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Н.Энхболд нар төсөлтэй холбогдуулан асуулт асууж, ажлын хэсгийн гишүүдээс хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан уг төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, төсөлд цөмийн технологийн энхийн хэрэглээнээс үүссэн цацраг идэвхт хаягдал, ураны олдворлолт, боловсруулалтаас үүсэх хаягдал болон хяналтад байгаа үйл ажиллагаанаас байгаль орчинд нийлүүлэх хаягдал, ашиглагдахгүй болсон битүү цацраг идэвхт үүсгүүр нь манай улс гадны цөмийн хаягдлыг нутаг дээгүүрээ дамжуулахгүй, тээвэрлэхгүй, хадгалахгүй, булшахгүй гэсэнтэй хэр нийцэж байгаа болохыг тодруулан асуусан бөгөөд энэ асуудлыг хэлэлцээр байгуулахдаа онцгой анхаарах шаардлагатай төдийгүй соёрхон батлах тухай хуулийн төсөлд тусгах шаардлагатай гэдгийг ажлын хэсгийнхэнд онцлон анхааруулсан болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг дэмжсэн болно.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

